

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/127/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АЛТАНХУЯГ ТАНАА

2024.02/25 № 01/102
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзлээ. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 5 арга хэмжээтэй боловсруулж 95,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

019020310

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,265,425.00	217,266,125.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,265,425.00	217,266,125.00
351	Түүхий эд материал	43,662,775.00	73,482,875.00
35110	Тусгай зориулалттай материал	43,662,775.00	73,482,875.00
354	Хангамжийн материал	26,602,650.00	143,783,250.00
35410	Бичиг хэргийн материал	-	3,678,400.00
35420	Аж ахуйн материал	26,404,900.00	140,044,600.00
35450	Барилгын засварын материал	137,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	60,250.00	60,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,057,705,098.69	5,141,763,793.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,057,705,098.69	5,141,763,793.68
392	Биет хөрөнгө	3,594,251,098.69	4,678,309,793.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,100,914,065.32	3,476,907,066.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(305,936,077.22)	(375,703,990.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,000.00)	(14,700,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,948,434.00	153,168,034.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,545,541.91)	(104,876,118.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,954,198.89	89,952,398.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,382,532.67)	(36,121,977.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	978,615,750.00	1,750,487,039.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(220,417,197.72)	(294,402,657.88)
393	Биет бус хөрөнгө	463,454,000.00	463,454,000.00
39301	Програм хангамж	495,000.00	495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(495,000.00)	(495,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	463,454,000.00	463,454,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,127,970,523.69	5,359,029,918.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,417,537.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,417,537.00	-
413	Өглөг	22,417,537.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,417,537.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,105,552,986.69	5,359,029,918.68
51	Засгийн газрын хувь оролцоо	4,105,552,986.69	5,359,029,918.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	463,454,000.00	463,454,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	463,454,000.00	463,454,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,566,830,932.47	4,820,307,864.46
51210	Өмнөх үеийн үр дүн	3,100,169,397.95	3,566,830,932.47
51220	Тайлант үеийн үр дүн	466,661,534.52	1,253,476,931.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,268,054.22	75,268,054.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,127,970,523.69	5,359,029,918.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,387,267,133.00	2,554,024,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	592,256,134.00	1,314,583,490.00
120	Нийтлэг татварын бус орлого	592,256,134.00	1,314,583,490.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	592,256,134.00	1,314,583,490.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,848,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	592,256,134.00	1,304,735,490.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,010,999.00	1,239,441,410.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,554,300.00	686,855,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,554,300.00	686,855,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,102,999.00	116,308,810.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,369,683.00	61,654,322.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,100,000.00	54,654,488.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,633,316.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	330,353,700.00	436,277,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	330,353,700.00	436,277,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	920,605,598.48	1,300,547,968.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	920,605,598.48	1,300,547,968.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,749,930.17	1,274,261,459.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,707,356.09	393,867,274.35
210101	Үндсэн цалин	163,392,342.67	238,410,838.93
210102	Нэмэгдэл	30,498,482.75	68,642,236.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,335,000.00	34,700,000.00
210104	Урамшуулал	17,481,530.67	52,114,198.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,398,383.60	48,497,068.40
210201	Тэтгэврийн даатгал	19,397,757.84	33,480,535.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,277,415.68	3,938,888.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,670.55	3,151,109.29
210204	Ажилгүйдлийн даатгал	445,230.94	687,988.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,452,308.59	7,238,545.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	332,911,637.00	381,877,892.17
210301	Гэрэл, цахилгаан	15,531,816.00	8,636,066.43
210302	Түлш, халаалт	312,676,737.00	368,007,189.74
210303	Цэвэр, бохир ус	4,703,084.00	5,234,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,322,059.00	48,731,800.00
210401	Бичиг хэрэг	216,470.00	278,960.00
210402	Тээвэр, шатахуун	10,780,179.00	15,571,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,932,290.00	2,195,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,821,120.00	23,548,150.00

210408	Бараа материал акталсны зардал	-	6,897,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,326,139.00	43,065,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	148,500.00
210604	Урсгал засвар	12,326,139.00	42,916,910.00
2107	Томилолт, зочны зардал	1,902,000.00	2,494,000.00
210702	Дотоод албан томилолт	1,902,000.00	2,494,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,240,495.00	2,736,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,851,400.00	116,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	950,000.00	1,234,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	510,000.00	510,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	312,000.00	-
210807	Газрын төлбөр	584,095.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,941,860.48	352,991,415.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,329,598.00	196,968,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,302,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,310,262.48	156,023,395.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,855,668.31	26,286,508.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,266,700.00	12,821,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,801,700.00	10,021,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,465,000.00	2,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	588,968.31	13,465,308.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	588,968.31	13,465,308.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	466,661,534.52	1,253,476,931.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	466,661,534.52	1,253,476,931.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	795,010,999.00	1,249,289,410.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,848,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,848,000.00
1E+05	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9,848,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,848,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,010,999.00	1,239,441,410.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,554,300.00	686,855,300.00
1E+05	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,554,300.00	686,855,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,102,999.00	116,308,810.00
1E+05	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,369,683.00	61,654,322.00

1E+05	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,100,000.00	54,654,488.00
1E+05	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,633,316.00	-
1E+05	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	330,353,700.00	436,277,300.00
1E+05	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	330,353,700.00	436,277,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	795,010,999.00	1,188,071,610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	795,010,999.00	1,188,071,610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	772,155,330.69	1,161,785,101.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,707,356.09	393,837,757.79
2E+05	Үндсэн цалин	163,392,342.67	225,135,414.63
2E+05	Нэмэгдэл	30,498,482.75	76,972,757.83
2E+05	Унаа хоолны хөнгөлөлт	17,335,000.00	39,368,217.30
2E+05	Урамшуулал	17,224,235.47	52,361,368.03
2E+05	Гэрээт ажлын хөлс	257,295.20	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,398,383.60	48,526,584.96
2E+05	Тэтгэврийн даатгал	19,397,757.84	33,478,278.60
2E+05	Тэтгэмжийн даатгал	2,277,415.68	3,938,623.63
2E+05	ҮОМШӨ-ний даатгал	1,825,670.55	3,161,789.11
2E+05	Ажилгүйдлийн даатгал	445,230.94	723,803.87
2E+05	Эрүүл мэндийн даатгал	4,452,308.59	7,224,089.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,494,100.00	404,295,429.17
2E+05	Гэрэл, цахилгаан	15,531,816.00	8,636,066.43
2E+05	Түлш, халаалт	290,259,200.00	390,424,726.74
2E+05	Цэвэр, бохир ус	4,703,084.00	5,234,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,061,710.00	25,401,330.00
2E+05	Бичиг хэрэг	1,372,800.00	1,199,960.00
2E+05	Тээвэр, шатахуун	2,860,000.00	2,500,000.00
2E+05	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,932,290.00	2,195,970.00
2E+05	Ном, хэвлэл		
2E+05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	240,000.00
2E+05	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,324,620.00	19,265,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,554,339.00	52,804,660.00
2E+05	Багаж, техник, хэрэгсэл	1,465,000.00	5,700,400.00
2E+05	Урсгал засвар	16,089,339.00	47,104,260.00
2107	Томилголт, зочны зардал	1,902,000.00	2,494,000.00
2E+05	Дотоод албан томилголт	1,902,000.00	2,494,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,937,095.00	5,620,100.00
2E+05	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,360,000.00	2,500,000.00
2E+05	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	950,000.00	1,234,600.00
2E+05	Даатгалын үйлчилгээ	510,000.00	510,000.00
2E+05	Тээврийн хэрэгслийн татвар	-	42,500.00
2E+05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2E+05	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
2E+05	Газрын төлбөр	584,095.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,100,347.00	228,805,240.00
2E+05	Бараа үйлчилгээний бусад зардал	168,198,347.00	228,805,240.00
2E+05	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,902,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,855,668.31	26,286,508.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,266,700.00	12,821,200.00
2E+05	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,801,700.00	10,021,200.00
2E+05	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,465,000.00	2,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	588,968.31	13,465,308.08
2E+05	Төвлөрүүлэх шилжүүлэг	588,968.31	13,465,308.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	61,217,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	61,217,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	61,217,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	61,217,800.00
2E+05	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	61,217,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(61,217,800.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	75,268,054.22	3,100,169,397.95	463,454,000.00	3,638,891,452.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,268,054.22	3,100,169,397.95	463,454,000.00	3,638,891,452.17
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	466,661,534.52	0.00	466,661,534.52
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,268,054.22	3,566,830,932.47	463,454,000.00	4,105,552,986.69
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	75,268,054.22	3,566,830,932.47	463,454,000.00	4,105,552,986.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,268,054.22	3,566,830,932.47	463,454,000.00	4,105,552,986.69
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	1,253,476,931.99	0.00	1,253,476,931.99
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,268,054.22	4,820,307,864.46	463,454,000.00	5,359,029,918.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,123,132,600.0	1,109,807,163.9	13,325,436.08	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,123,132,600.0	1,109,807,163.9	13,325,436.08	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,311,400.0	1,096,985,963.9	13,325,436.08	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,286,100.0	392,188,757.8	2,097,342.21	99.5
210101	Үндсэн цалин	231,643,200.0	225,135,414.6	6,507,785.37	97.2
210102	Нэмэгдэл	86,249,100.0	75,323,757.8	10,925,342.17	87.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,111,200.0	39,368,217.3	7,742,982.70	83.5
210104	Урамшуулал	29,282,600.0	52,361,368.0	(23,078,768.03)	179.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш	49,285,800.0	48,320,447.0	965,353.04	98.0
210201	Тэтгэврийн даатгал	33,514,300.0	33,336,044.6	178,255.40	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,942,900.0	3,921,889.6	21,010.37	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,154,300.0	3,137,510.1	16,789.89	99.5
210204	Ажилгүйдлийн даатгал	788,600.0	720,454.9	68,145.13	91.3
210205	Эрүүл мэндийн даатгал	7,885,700.0	7,204,547.8	681,152.25	91.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,077,300.0	404,295,429.2	9,781,870.83	97.7
210301	Гэрэл, цахилгаан	12,406,400.0	8,636,066.4	3,770,333.57	70.0
210302	Түлш, халаалт	396,762,000.0	390,424,726.7	6,337,273.26	98.4
210303	Цэвэр, бохир ус	4,908,900.0	5,234,636.0	(325,736.00)	107.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,336,000.0	8,975,930.0	360,070.00	96.1
210401	Бичиг хэрэг	1,200,000.0	1,199,960.0	40.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.0	2,500,000.0	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.0	1,535,970.0	30.00	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн у	600,000.0	240,000.0	360,000.00	40.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.0	3,500,000.0	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,000,000.0	87,996,160.0	3,840.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,800,000.0	45,800,000.0	-	100
210602	Тавилга	20,000,000.0	19,998,200.0	1,800.00	99.9
210604	Урсгал засвар	22,200,000.0	22,197,960.0	2,040.00	99.9
2107	Томиллолт, зочны зардал	2,500,000.0	2,494,000.0	6,000.00	99.8
210702	Дотоод албан томиллолт	2,500,000.0	2,494,000.0	6,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	5,340,500.0	5,335,500.0	5,000.00	99.9

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,500,000.0	2,500,000.0	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	950,000.0	950,000.0	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	510,000.0	510,000.0	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.0	42,500.0	5,000.00	89,5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	33,000.0	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.0	500,000.0	-	100
210807	Газрын төлбөр	800,000.0	800,000.0	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,485,700.0	147,379,740.0	105,960.00	99,9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	147,485,700.0	147,379,740.0	105,960.00	99,9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,821,200.0	12,821,200.0	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,821,200.0	12,821,200.0	-	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө	10,021,200.0	10,021,200.0	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.0	2,800,000.0	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,123,132,600.0	1,123,132,600.0	-	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,123,132,600.0	1,123,132,600.0	-	100
122005	Орон нутгийн төсвөөс	1,123,132,600.0	1,123,132,600.0	-	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны зорилго нь иргэдийг эрүүл чийрэг байлгах, тэднийг биеийн тамир спортоор хичээллэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Тус байгууллага нь Олимп, нийтийн биеийн тамир спортын сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь 2023 оныг түүхт ой бүтээн байгуулалтын жил болгон зарлаж 1 зорилт 5 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөг 95,0 хувиар биелүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Биеийн тамир спортын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард Аймгийн Засаг даргын газраас байгууллагын дотоод үйл ажиллагаанд шалгалт орсон. Ажлын үзүүлэлт 98,5 хувь гэж дүгнэсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,253,477.0 мянган төгрөгөөр буюу 26,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	70,265.4	217,266.1	147,000.0
Үндсэн хөрөнгө	4,057,705.0	5,141,763.7	1,084,058.7
Нийт хөрөнгө	4,127,970.5	5,359,029.9	1,231,058.7
Өр төлбөр	22,417.5		
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,105,552.9	5,359,029.9	1,253,477.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,105,552.9	5,359,029.9	1,253,477.0

2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй. Мөнгөн хөрөнгө 13,465.3 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн.

Авлага дансны үлдэгдэл байхгүй.

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 147,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төв аймгийн 100 жилийн ойтой холбоотой аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас асар, бөхийн засуулын дээл малгай, хиймэл зүлэг, цэнгэлдэх хүрээлэнгийн сандал зэрэг хөрөнгө хүлээж авснаас шалтгаалан нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,084,058.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төв аймгийн 100 жилийн ойтой холбоотой улсын төсвөөс 60,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий конторын тавилга, тоног төхөөрөмж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 1,024,058.7 мянган

төгрөгийн үнэ бүхий нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын засвар, бөхийн барилдааны талбай, явган хүний зам талбайн тохижилт зэрэг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд 22,417.5 мянган төгрөг нь Дулааны үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан төлбөр бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулж барагдуулсан байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 686,800.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 436.200.0 мянган төгрөг нийт зарлагыг 1,123.000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,123.000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,123.000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 686,800.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 436.200.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,110.000.0 мянган төгрөг буюу 98,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны тогтмол зардлаас 9,700.0 мянган төгрөгийг, улсын төсвийн хувьд орон тоо дутуу ажилласнаас 3,500.0 мянган төгрөгийг тус тус хэмнэж нийт 13,465.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Дансны код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71701	Биеийн тамир спорт хөтөлбөр	1,123,000.0	1,109,600.0	13,400.0	98.8
80305	Биеийн тамир уралдаан тэмцээн арга хэмжээ	96,419.4	96,419.4		100.0
82106	Нийтийн биеийн тамир	48,066.3	48,066.3		100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	12,821.2	12,821.3		100.0
80111	Төрийн өмчит барилгын тогтмол зардал	436,277.3	426,493.4	9783.0	97.7
80101	Үндсэн үйл ажиллагаа	686,855.3	683,355.3	3,500.0	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 онд 126,156.8 мянган төгрөгийн нэмэлт төсвийн санхүүжилтийг орон нутгийн төсөв УИХ-ын тамгын газар, Биеийн тамир спортын улсын хорооноос тус тус авч уралдаан тэмцээнд 81,425.5 мянган төгрөгийг, урсгал засварт 26,026.3 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 16,425.4 мянган төгрөг, нэмэгдэл цалинд 1,649.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Биеийн тамир спорт хөтөлбөр	2023 он	100	100	1,123,000.00	1,109,600.00
	дүн				1,123,000,00	1,109,600,00

Хэрэгжилт хангаагүй төсөл хөтөлбөр байхгүй

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй.

Аймгийн орон нутгийн худалдан авах ажиллагааны газар нь Биеийн тамир, спортын газрын бүх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 70,256.0 мянган төгрөгөөр хянаж баталсан.

Хангамжийн бараа материалыг Мандухай цэцэн ХХК-аас, цэвэрлэгээний бараа материалыг Их дэвжих ХХК-аас, хэвлэмэл материал хулдаасан хэвлэл зэргийг авдаг. Худалдан авах ажиллагааны холбогдох хууль дүрмийн дагуу явагдсан гэж үзлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 420,000,0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 8,400.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,720.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь 2023 онд 25 орон тоотой ажиллахаас 23 орон тоотой ажиллаж спорт тоглоомын 2 дасгалжуулагчийн орон тоог хэмнэсэн. 2023 онд нийт цалингийн төсвийг 25,102.3 мянган төгрөгөөр хэмнэсэн. Төрийн хэмнэлтийн хууль сайн хэрэгжсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 157 мэдээллийг хугацаанд нь оруулж, 2 мэдээлэл /Хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн батлагдсан төсвийн гүйцэтгэл/ хугацаа хоцроож шилэн дансанд байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж зөвлөмж бичлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт /нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны завсрын аудитаар нийт 3 эрсдэл тодорхойлон 2 алдааг залруулах, 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Төв аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн 52,024.8 мянган төгрөгийн гүйцэтгэлийг шалган үзэхэд баримтын бүрдэл дутуу, мөн ээлжээр ажилладаг ажилчдын илүү цагийн хөлсийг бодож олгоогүй 1,000.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулав.
- 1,975.0 мянган төгрөгийн тэмцээний зардлын баримтад нягтлан бодогч гарын үсэг зураагүй зэрэг алдааг шалгалтын хугацаанд бүрдүүлж залруулах зөвлөмж өгөв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн актын биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,300.0	1	1,300.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	1	1,300.0	1	1,300.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 54,999.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 53,024.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,975.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болсон төсвийн гүйцэтгэлийн тайланд түүвэр шалгалт хийхэд Төв аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнд хийгдсэн засварын ажлын гүйцэтгэл 52,024.8 мянган төгрөгийн зардалд гарын үсэг, тамга тэмдэггүй зэрэг баримтын бүрдэлт дутуу Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ээлжийн ажилтай ажилчдын илүү цагийн хөлсийг бодож олгоогүй байсан 1,000.0 мянган төгрөгийг шалгалтын хугацаанд бодож олгуулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15,2-т Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт залруулсан алдааны дүн 53024.8 мянган төгрөг байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны 9 сард 30 ширхэг нийт 1,975.0 мянган төгрөгийн гадуур хүрмийг тэмцээнд оролцогчдод тараан өгсөн боловч зарим оролцогчид гарын үсэг зурж баримтын бүрдэл хангаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. тус тус зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангаж, анхан шатны бүртгэлээр тавигдах хяналтыг сайжруулан зөрчлийг дахин гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төв Аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн акт дутуу	1	52,024.8					1	52,024.8				
Ээлжийн ажилтай ажилчдын илүү цагийн хөлсийг бодож олгоогүй	1	1,000.0					1	1,000.0				
Дүн	2	53,024.8					1	53,024.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2023 оны 9 сард тэмцээнд оролцогчдод тараан өгсөн 30 ш гадуур хүрмийн баримтад зарим тамирчдаар гарын үсэг зуруулаагүй	1	1,975.0					1	1,975.0				
Дүн	1	1,975.0					1	1,975.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2023 онд шилэн дансанд оруулах 159 мэдээллээс 157 г хугацаанд нь оруулж, 2 мэдээлэл хугаа хоцроож байршуулсан/Төсвийн тодотгол тайлан, өмнөх аудитын биелэлт /	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	1						1	
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn